



## МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХУРАЛДААНЫ 2018 ОНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (цаашид ХХЗХ гэх)-ноос тайлангийн хугацаанд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, ХХЗХ-ны Дарга /буюу Төсвийн шууд захирагч/ болон Монгол Улсын Ерөнхий сайд /буюу Төсвийн ерөнхийлөн захирагч/ нарын хооронд 2018 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний 6 ангилал, 27 бүлэг нийт 253 зорилт, арга хэмжээ, төлөвлөгөөт ажил болон удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, бусад ажлын хүрээнд арга хэмжээ (зохицуулалтын баримт бичиг, давтамжийн хуваарилалт, ашиглалт, төлбөрийн хэмжээ, төсөл хөтөлбөр)-ний талаар Даргын зөвлөл, Хорооны хуралдаанаар тус тус хэлэлцэн шийдвэрлэж, хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан болно.

ХХЗХ-ны Дарга, Хорооны хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэл, хуралдааны дэгийн дагуу Хорооны ээлжит хуралдааныг 2018 онд нийтдээ 11 удаа зохион байгуулж (хуралдааны нийлбэр хугацаа: 59 цаг), байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөт болон цаг үеийн нийтдээ 68 асуудлыг хэлэлцэн хорооны 46 тогтоол, хуралдааны 16 удаагийн тэмдэглэл гарган тус тус шийдвэрлэсэн болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны хэмжээнд 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, ХХЗХ-ны хуралдаанаар баталсан хүчин төгөлдөр мөрдөж буй тогтоол, шийдвэрийн нийтдээ 76 эрх зүйн зохицуулалтын баримт бичиг байгаа бөгөөд үүнээс, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд бүртгүүлэх шаардлагагүй 7 баримт бичиг (Тухайлбал, Дэд бүтцийн Сайдын 2003 оны 39 болон 216 дугаар тушаал, ХХЗХ-ны 2011 оны 06, 2014 оны 59, 2015 оны 41, 2016 оны 43, 2018 оны 04 дүгээр тогтоол); ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд хянуулан бүртгүүлсэн 9 захиргааны хэм хэмжээний акт (ХХЗХ-ны 2017 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан 2 баримт бичиг болон 18 дугаар, 31 дугаар, 32 дугаар, 58 дугаар тогтоол, 2018 оны 17, 23, 24 дүгээр тогтоол) зэрэг болно.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 161 тоот захирамжаар өөр ажилд шилжих болсонтой холбогдуулан Хорооны дарга С.Адьяасүрэнг үүрэг ажлаас нь чөлөөлж, ХХЗХ-ны даргаар Гончиг овогтой Чинзоригийг Ерөнхий Сайдын 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 162 тоот захирамжаар томилсон болно.

ХХЗХ-ны орон тооны бус гишүүнээр Ерөнхий Сайдын 2016 оны 133 дугаар захирамжаар Эрдэнээгийн Энхтуяа, Эрдэнэдалайгийн Алтанбагана; 2018 оны 17 дугаар захирамжаар Пүрэвийн Сэргэлэн нарыг Харилцаа холбооны зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаагаар тус тус томилсон бөгөөд дээрх нэр бүхий 3 орон тооны бус хорооны гишүүний ажиллах бүрэн эрхийн хугацаа дууссан болно. Иймээс томилогдсон бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тус



хорооны орон тооны бус 3 гишүүний асуудлыг Харилцаа холбооны тухай хуулийн 8.3, 8.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий Сайдын Захирамжаар шийдвэрлүүлэх талаар Хорооны Даргын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/1765 албан тоотыг боловсруулан хүргүүлсэн болно. Улмаар, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 214 дугаар захирамжаар Эрдэнээгийн Энхтуяа, Эрдэнэдалайгийн Алтанбагана; Жалавсүрэнгийн Бат-Эрдэнэ нарыг Харилцаа холбооны зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хүртэл хугацаагаар тус тус томилсон болно.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрхзүйн орчинг тухай бүр шинэ нөхцөлд нийцүүлэн боловсронгуй болгох, төрөөс салбарын талаар баримтлах бодлого, зохицуулалтын стратегиуд, тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааг тодорхойлсон баримт бичгүүд, түүний хэрэгжилтийг хангуулах арга, механизмыг оновчтой зөв тодорхойлох нь нэн чухал ач холбогдолтой байдаг.

Тус хороо нь “Харилцаа холбооны тухай”, “Шуудангийн тухай”, “Радио долгионы тухай”, “Цахим гарын үсгийн тухай”, “Сонгуулийн тухай” болон холбогдох Монгол Улсын хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж эдгээр хуулиудад тусгайлан заасан эрх үүргүүдийг хэрэгжүүлж байна. ХХЗХ-нд дараах холбогдох хуулийг мөрдөж ажиллаж байна:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай;
- Өрсөлдөөний тухай;
- Захиргааны Ерөнхий хууль;
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай;
- Зар сурталчилгааны тухай;
- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай;
- Засгийн газрын тусгай сангийн тухай;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай;
- Шилэн дансны тухай;
- Хэрэглэгчийн эрхийн тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай;
- Төрийн хяналт шалгалтын тухай;
- Зөрчлийн тухай;
- Олон нийтийн радио , телевизийн тухай болон МУ-ын бусад хуулиуд.

ХХЗХ-ноос 2018 онд мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтын чиглэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөж буй зохицуулалтын баримт бичиг болох 30 гаруй дүрэм журам, нөхцөл шаардлага, техникийн нөхцөл, давтамжийн зохицуулалт, хуваарилалтын баримт бичгийн эрх зүйн актад дүн шинжилгээ, мониторинг хийснээр Захиргааны ерөнхий хууль, хууль тогтоомжид нийцүүлэн дараах зохицуулалтын баримт бичгүүдийг ХХЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Үүнд:



- Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хүүхэд хамгаалах чиглэлээр баримтлах зөвлөмж;
- Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай (Олон сувгийг олон цэгт түгээх системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага);
- Зохицуулалт, нөхцөл шаардлагад нэмэлт оруулах тухай (2015 оны 15 тоот тогтоолын хавсралт);
- “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тогтоож, батлах тухай (2018 оны 23 тоот тогтоолын хавсралт);
- Тоон радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай (DAB+);
- Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай;
- Үнэ тариф тогтоох тухай (Жемнет ХХК-ийн “Дотоодод борлуулах интернетийн урсгалын бөөний үйлчилгээний доод үнэ”);
- Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагад нэмэлт оруулах тухай (Хорооны 2017 оны 42 тоот болон 44 тоот тогтоол);
- Тогтоол хүчингүй болгох тухай (Хорооны 2018 оны 35 тоот тогтоол: Захиргааны ерөнхий хуульд нийцээгүй, хуулиар журам гаргах эрх олгоогүй, үйлчлэх хугацаа дууссан, шинэчлэн батлах шаардлагатай журам, нөхцөл шаардлага, нэмэлт өөрчлөлтийг оруулж баталсан, дотооддоо Даргын тушаалаар батлан мөрдөх боломжтой зарим зохицуулалтын баримт бичгүүд-8) зэрэг зохицуулалтын баримт бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн тогтоож баталсан, хүчингүй болгох арга хэмжээг тус тус авч хэрэгжүүлэв.

Хорооны хуралдаанаар салбарын зохицуулалтын баримт бичиг, дүрэм журам, нөхцөл шаардлагын шинэчлэлтийг хийх явцад одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа зохицуулалтын баримт бичгийн 30 гаруйг багцлан шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Тайлангийн хугацаанд ХХЗХ-ны 2018 оны ээлжит 10 удаагийн хуралдаанаас баталсан тогтоол, шийдвэрийн жагсаалтыг хавсралт-1-д нэгтгэн үзүүлэв. (2018 оны тогтоол, шийдвэрийг нэгтгэн үзүүлбэл):

- Зохицуулах хорооны үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрхзүйн хэм хэмжээний акт буюу зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлага, давтамжийн хуваарилалт ба төлөвлөлтийн баримт бичиг-76;
- Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчилэн тогтоож баталсан 5 зохицуулалтын баримт бичиг, давтамжийн хуваарилалт, нөхцөл шаардлага ХЗДХЯ-нд нийтээр даган мөрдөх хэм хэмжээнд хянуулан бүртгүүлэхээр албан тоотоор хүргүүлсэн ба ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд 3 баримт бичгийг бүртгүүлсэн болно.
- Шинээр боловсруулж батлуулсан (техникийн нөхцөл шаардлага, давтамжийн хуваарилалт, зөвлөмж, үнэ тариф тогтоох)-9;
- Тогтоолын хавсралт болон тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан-4;



- Захиргааны ерөнхий хуулийн дагуу шинэчлэн баталсан болон үйлчлэх хугацаа хугацаа дууссан, хүчингүй болгосон-18 баримт бичиг зэрэг болно.

Зохицуулах хорооны 2018 оны хуралдаанаар баталж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд хянуулан бүртгүүлсэн 3 баримт бичгийг Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ([www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)), хорооны цахим хуудас ([www.cfc.gov.mn](http://www.cfc.gov.mn))-д тус тус байршуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 11 удаагийн хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрлийн талаар баталсан нийт 30 тогтоол, шийдвэрээр:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, тус хорооны 2013 оны 37 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг болон хорооноос хийсэн гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүгнэлтийг тус тус үндэслэн 125 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл шинээр олгох;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, тус хорооны 2013 оны 37 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 26 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хамрах хүрээ ба давтамжийн зурваст нэмэлт өөрчлөлт оруулах;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дах заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг тус тус үндэслэн 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг сэргээх;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, тус хорооны дүрмийн 3 дугаар зүйлийн 2.2 дах заалт болон хяналт, шалгалтын ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн үндэслэн 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.4 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3 дэх заалт, тус хорооны 2013 оны 37 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1 дах заалт болон тухайн аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтүүдийг тус тус үндэслэн 34 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг тус тус тогтоолоор батлан шийдвэрлэсэн болно.



ХХЗХ-ны хуралдааны тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, батлагдсан зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлагын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд ЗГХЭГ, холбогдох яам-ХЗДХЯ, ХХМТГ, ТӨБЗГ, ҮДТ, ШӨХТГ, ОӨУБЕГ, ХТГ, ЦЕГ зэрэг байгууллага, дүүрэг, татварын алба, мэргэжлийн хяналтын газар, ААН, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээд нарт 1400 гаруй албан тоотоор тус тус албажуулан хүргүүлэх арга хэмжээг авч ажиллав. Үүнд: “Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хүүхэд хамгаалах чиглэлээр баримтлах зөвлөмж”; Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай (Олон сувгийг олон цэгт түгээх системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага); Зохицуулалт, нөхцөл шаардлагад нэмэлт оруулах тухай (2015 оны 15 тоот тогтоолын хавсралт); “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тогтоож, батлах тухай; Тоон радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай (DAB+); Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай; Үнэ тариф тогтоох тухай (Жемнет ХХК-ийн “Дотоодод борлуулах интернетийн урсгалын бөөний үйлчилгээний доод үнэ”); Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагад нэмэлт оруулах тухай (Хорооны 2017 оны 42 тоот болон 44 тоот тогтоол); Тогтоол хүчингүй болгох тухай (ЗЕХ-д нийцүүлэх, хэрэгжүүлэх-8 тогтоол) зэрэг болно. “Мөн МХС, БНҮҮС, Оюу толгой ХХК, МЦХ ХК, Мобиком ХХК, Скайтел ХХК, Юнител ХХК, Жи-Мобайл ХХК, Рэйлком төв, ТЕГ зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигч, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тогтоолыг хавсралтын хамт албажуулан албан тоотоор хүргүүлж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

ХХЗХ-ны Дарга /буюу Төсвийн шууд захирагч/ болон Монгол Улсын Ерөнхий сайд /буюу Төсвийн ерөнхийлөн захирагч/ нарын хооронд 2018 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний төсөвт хорооны хуралдааны зардалд нийтдээ 183,024 сая төгрөг батлуулсан болно. Хорооны 2018 оны төсвийн гүйцэтгэлээр /2018-12-31/:

- Хорооны хуралдааны зардлаас хорооны дарга, гишүүдийн хуралдааны урамшуулал цагийн хөлс-32,3 сая төгрөг;
- Хорооны дарга ба гишүүдийн НДШ, ХХОАТ-14,31 сая төгрөг; хуралдааны бичгийн зардалд 3,9 сая төгрөг;
- Цайны зардал 0,84 сая төгрөг;
- Бэлэг дурсгал 1,42 сая төгрөг;
- Сургалт семинар, ажлын хэсгийн зардал 7,96 сая;
- Гадаад дотоод арга хэмжээ ба томилолтын зардал 57,62 сая;
- Урамшуулал 50,0 сая төгрөгийн зардлыг тус тус гаргаж, нийтдээ 168,35 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна.

Хорооны хуралдааны зардлаар улсад харилцаа холбоо, мэдээллийн технологийн бодлого, зохицуулалтын чиглэлээр олон улсын хурал чуулган, үзэсгэлэн яармагт хорооны гишүүн



Б.Чинбат (АНЭУ: 7,27 сая төг), П.Сэргэлэн (АНУ: 10,59 сая төг), Э.Алтанбагана (Испани: 8,97 сая төг), Э.Энхтуяа (БНСУ: 4,5 сая төг), Б.Балгансүрэн (Сингапур: 5,21 сая төг) нар албан томилолтоор ажилласан болно. 2018 онд хорооны хуралдааны зардалд төлөвлөн батлуулсан 183,024 сая төгрөгийн төсвөөс нийтдээ 168,35 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд хорооны хуралдааны зардлын зарцуулалт нь төлөвлөсөн төсвийн 91,9 хувь болсон болно.

ХХЗХ-ны Дарга, Хорооны хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэл, хуралдааны дэгийн хүрээнд ажлын албадаас боловсруулсан 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөт болон цаг үеийн нийт 70 шахам асуудлыг хэлэлцэж, хорооны хуралдааны 46 тогтоол, 16 хуралдааны тэмдэглэл гарган шийдвэрлэсэн бөгөөд хуралдаан тус бүрээр тоймлон үзүүлбэл:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 1 дүгээр хуралдааныг 2018 оны 1 дүгээр сарын 31-ний зохион байгуулав. Тус хорооны хуралдаанаар “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналын тухай (Хорооны хуралдааны 2017 оны 15 дугаар тэмдэглэл); ХХЗХ-ны хуралдааны 2017 оны жилийн тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тухай; тусгай зөвшөөрлийн талаар холбогдох газрууд, Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга нараас боловсруулсан нийтдээ 3 асуудлыг хэлэлцэж, хорооны хуралдааны 3 тогтоол, 2 тэмдэглэлийг тус тус батлан шийдвэрлэсэн болно.
  - Тус хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газраас хорооны 2017 оны ээлжит 10 дугаар хуралдааны 15 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухай танилцуулгыг 2018 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаар авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 2018 оны оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны “Нөхцөл, шаардлагын талаар авах арга хэмжээний тухай” 02 дугаар тэмдэглэлийг гаргахаар шийдвэрлэж, “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, зохицуулалтын арга хэмжээний саналын талаар эрх ашиг нь хөндөгдөж буй үйлчилгээ эрхлэгч, хуулийн этгээд, оролцогч талуудтай хамтарсан зөвлөгөөнийг Зохицуулах хорооноос зохион байгуулах, санал хүсэлийг хүлээн авч ажиллах, тусгах нь зүйтэ й гэж үзэв.
  - Зохицуулах хорооны 2018 оны ээлжит 1 дүгээр хуралдаанаар “ХХЗХ-ны хуралдааны 2017 оны жилийн тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тухай” танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төслийг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга Т.Наранмандахаас нэгтгэн боловсруулж танилцуулав. Хэлэлцүүлсэн тайланд, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны хуралдааны жилийн эцсийн тайлан болон баталсан тогтоол шийдвэр удирдамж чиглэл; хугацаатай үүрэг даалгавар өгсөн хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн талаар хуралдаанаар авч хэлэлцээд, гишүүдийн зүгээс 2017 онд зохион байгуулсан хорооны 12 ээлжит болон 1 ээлжит бус хуралдааны 62 тогтоол шийдвэр, 23 удаагийн хуралдааны



тэмдэглэлийг тус тус батлан шийдвэрлэж, тогтоол болон тэмдэглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан бөгөөд тогтоол, хуралдааны тэмдэглэлээр өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангалттай гэж дүгнэв. Тус хуралдаанаас “Хорооны хуралдааны 2017 оны жилийн эцсийн тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тухай” 2017 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн хорооны хуралдааны 01 дугаар тэмдэглэлийг гаргаж, холбогдох удирдамж чиглэлийг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/, холбогдох газрын дарга нарт өглөө. Энэхүү тэмдэглэлд, тодорхой шалтгааны улмаас бүрэн хэрэгжээгүй, хугацаа болоогүй хуралдааны 3 тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд шийдвэрлэх талаар санал боловсруулж, 2018 оны 1 дүгээр улиралд багтаан хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга; Хорооны тогтоол шийдвэр, зохицуулалтын баримт бичгийг Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх арга хэмжээг (шинэчлэн батлах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох) эрчимжүүлэх; ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд бүртгүүлэх, тус яамнаас ирүүлсэн дүгнэлтийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах арга хэмжээг тухай бүр шуурхай авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/, Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д тус тус үүрэг болгохоор тогтов. Түүнчлэн хорооны гишүүдийг шаардлагатай мэдээлэл зөвлөмжөөр хангах, хуралдааны үеэр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, гадаад дотоод албан томилолтоор ажиллах, тайлагнахад хамтран ажиллах, хорооноос 2018 онд зохион байгуулах салбарын болон бүсийн сургалт семинар, хэлэлцүүлэг, хамт олны арга хэмжээнд оролцуулах, дэмжлэг үзүүлэх; хорооны 2018 оны тогтоол, хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн тайланг хагас жил, жилийн эцсээр нэгтгэн хорооны хуралдаанд танилцуулан холбогдох удирдамж, чиглэл авч ажиллахыг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д үүрэг болгож, энэхүү тэмдэглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнан ажиллахыг Хорооны дарга-д даалгав.

➤ Тус хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг авч хэлэлцэв. Хэлэлцсэн асуудлаар дараах тогтоолыг батлан шийдвэрлэв:

- 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 01 тоот тогтоолын хавсралтаар нийт 5 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
- 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 02 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулсан;
- 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 03 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон болно.

2. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 2 дугаар хуралдаан 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдөр болов. Энэхүү хорооны хуралдаанаар “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах зөвлөмж”-ийн төслийн тухай (Хуралдааны



2017 оны 16 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлэх); тусгай зөвшөөрлийн талаар холбогдох газар, хэлтсээс боловсруулсан үндсэн 2 асуудлыг хэлэлцэж, хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 4 тогтоолыг баталсан болно.

- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны ээлжит 10 дугаар хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах зөвлөмж”-ийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан боловсруулж хорооны хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг үүрэг болгосон юм. Өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн хөтөлбөрөөр хүүхдийн хөгжил, хүмүүжил төлөвшил, эрүүл мэнд, сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх агуулга, зохисгүй бүдүүлэг үг хэллэг бүхий кино бүтээл, нэвтрүүлэг гарсаар байна. Үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд телевиз, сувгаар дамжуулж байгаа хөтөлбөртэй холбоотой, ялангуяа эротик, садар самуун кино, дүрс бичлэг, бүдүүлэг үг хэллэг, хараалын үг ихээр ашигласан кино, нэвтрүүлэг эфирт гаргаж байгаа талаар үзэгчид, эцэг, эхчүүд, ТББ-ийн зүгээс гомдол, санал ХХЗХ-д ирсээр байна. Хэдийгээр гомдлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа ч ямар нэвтрүүлэг, кино бүтээл, үг хэллэг нь хүүхдийн хүмүүжил төлөвшил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, ямар нэвтрүүлэг, кино бүтээлийг хүүхдийн нас, бие сэтгэхүйн онцлогт тохирсон гэж үзэх нь эрхзүйн зохицуулалт тодорхойгүй байдаг. Зохицуулах хорооноос “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ын хүрээнд “Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага” MNS6587:2016 стандартыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах ажил хийгдэж байгаа ч тухайн телевизийн нэвтрүүлгийг ангилал шалгуур үзүүлэлт байхгүй, энэхүү стандартад тусгаагүй, тэдгээрийг тодорхойлон тогтоох холбогдох мэргэжлийн баг, зөвлөл байхгүй байгаа нь хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон, хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц агуулгыг тодорхойлох, дүгнэлт гаргах, хяналт тавих, гомдолд хариу өгч шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудлууд тулгарсаар байна. Иймээс одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд олон улсын туршлага, практик судалгааг хийж, Монгол орны онцлог, уламжлалыг харгалзсан, өргөн нэвтрүүлгийн орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх, олон улсын хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн утга агуулгыг тодорхойлон төрийн байгууллага, ТББ, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид болон олон нийтэд хандсан зөвлөмж хэлбэрээр тус хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газраас “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах зөвлөмж”-ийн төсөл, танилцуулга, тогтоолын төслийг тус тус боловсруулан хорооны 2018 оны ээлжит 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэв. Тус хорооны хуралдаанаас Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дах заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дах хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4, 5.3.7 дах заалтыг тус тус үндэслэн Хорооны “Зөвлөмж батлах тухай” 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 04 тоот тогтоолыг батлав. Уг тогтоолын хавсралтаар “Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хүүхэд хамгаалах чиглэлээр баримтлах зөвлөмж”-ийг баталсан бөгөөд зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд зөвлөмж болголоо.





- Энэхүү хорооны хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг авч хэлэлцээд, хуралдааны дараах тогтоолыг батлан шийдвэрлэв:
  - 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 05 тоот тогтоолын хавсралтаар нийтдээ 13 хуулийн этгээдэд 14 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
  - 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 06 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд өөрчлөлт оруулсан;
  - 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 07 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.
- 3. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 3 дугаар хуралдааныг 2018 оны 3 дугаар сарын 29-ны өдөр зохион байгуулав. Уг хорооны хуралдаанаар Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай (Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг); “Радио, телевизийн салбарын зах зээлийн багтаамжийг тодорхойлох судалгааны тайлан”-гийн талаар танилцуулга; Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлагын хэрэгжилтийг хангуулах тухай (Мониторингийн үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал); “Жемнэт ХХК-ийн интернэтийн бөөний үйлчилгээний үнэ тарифт зохицуулалт хийх тухай” танилцуулга; Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн (МҮОНРТ)-иэс өөрийн нэмэлт сувгийн хөтөлбөрийг олон нийтэд хүргэх талаар ирүүлсэн хүсэлтийн тухай; тусгай зөвшөөрлийн талаар холбогдох газар, хэлтсээс боловсруулсан санал дүгнэлт, тогтоолын төсөл зэрэг үндсэн 6 асуудлыг хэлэлцэж, хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 4 тогтоол, хуралдааны 3 тэмдэглэлийг баталсан болно.
  - Хуралдаанд тус хорооны 2016 оны 43 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийн 5.11 заалтад нэмэлт оруулах тухай танилцуулга, тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлэв. “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг үндэслэн “Нэмэлт оруулах тухай” 2018 оны 3 дугаар сарын 29-ны 08 дугаар тогтоолыг батлав. Энэхүү нэмэлтийг “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-д оруулснаар хорооны хуралдааны шийдвэрийг албажуулан байгууллага, иргэн, ААН-д хүргүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах, байгууллагын цахим хуудаст тогтоол шийдвэрийг эх хувийг албажуулан байршуулах боломжийг бүрдүүлсэн.
  - Тус хуралдаанд Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газраас “Радио, телевизийн салбарын зах зээлийн багтаамжийг тодорхойлох судалгааны тайлан”-гийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийлээ. Судалгаагаар телевиз, радиогийн салбарын зах зээлийн багтаамжийг судалж, салбарын тоглогчдод нөлөөлж байгаа хүчин зүйлс, тоглогчдын зохистой тоо хэмжээг тодорхойлж телевиз, радиогийн бизнесийн орчны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн бодит судалгаа гаргаснаар өргөн нэвтрүүлгийн эрүүл хөгжлийг дэмжихэд шаардлагатай асуудлууд, тусгай зөвшөөрөл олголтын өнөөгийн байдал, олголтын зарчим, шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ



хийж, шаардлагатай зохицуулалтын арга хэмжээг тодорхойлсон байна. Цаашид уг судалгааны үр дүнд тулгуурлан радио, телевиз, сувгийн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, өргөн нэвтрүүлгийн хөгжлийг дэмжих, тусгай зөвшөөрлийн үйлчилгээг сайжруулах цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхээр тогтов.

- Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.5 дахь хэсэгт “харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах” тухай заасныг үндэслэн ШӨХТГ-ын шийдвэрээр интернетийн бөөний урсгалын үйлчилгээний зах зээлд давамгайл байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдсон “Жемнет ХХК”-ийн үйлчилгээний үнэ тарифид зохицуулалт хийх тухай таницуулгыг 2018 оны ээлжит 3 дугаар хуралдаанаар авч хэлэлцээд, тус хорооны 2018 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн “Үнэ тарифын талаар авах арга хэмжээний тухай” 03 дугаар хуралдааны Тэмдэглэлээр хорооны нэр бүхий гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийн дагуу холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд эрх ашиг нь хөндөгдөж буй тухайн компанид хүргүүлэн саналыг албан ёсоор авч асуудлыг боловсруулж, Хорооны 2018 оны ээлжит 4 дүгээр хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж тогтов.
- Тус хорооны хуралдаанаар Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар болон ажлын хэсгээс боловсруулсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлагын хэрэгжилтийг хангуулах тухай (Мониторингийн үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал)” танилцуулга, цаашид хэрэгжүүлэхээр санал болгож буй нэр бүхий хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 сараар түдгэлзүүлэх, хамрах хүрээг өөрчлөх, 9-12 сарын хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэх, хүчингүй болгох дүгнэлтийн талаар тус тус хэлэлцэв. Хорооны 2018 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн хуралдааны “Хяналт, мониторингийн үр дүнгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр Тэмдэглэлээр, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалтын тайлан, үр дүнгийн талаар хамаарал бүхий этгээдэд хуульд заасан аль нэг хэлбэрээр танилцуулж мэдэгдэх, мэдэгдсэн талаар хариуг албажуулан авах; Захиргааны ерөнхий хуулийн хэм хэмжээнд нийцүүлэх, хуулийн дагуу процессыг гүйцэтгэх, шат шатны арга хэмжээг хэрэгжүүлж, улмаар нэр бүхий хуулийн этгээд нарт хариуцлага тооцох, арга хэмжээ авах санал, дүгнэлтээ эцэслэн боловсруулж, Хорооны дараагийн ээлжит хуралдаанд хэлэлцүүлэхийг холбогдох газар, ажлын хэсэгт үүрэг болгов.
- Тус хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, дүгнэлт болон тогтоолын төслийг авч хэлэлцээд, хорооны хуралдааны дараах тогтоолыг батлан шийдвэрлэв:
  - 2018 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 09 тоот тогтоолын хавсралтаар нийтдээ 23 хуулийн этгээдэд 23 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
  - 2018 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 10 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд өөрчлөлт оруулсан;



- 2018 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн 11 тоот тогтоолоор 3 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон болно.
  - Тус хорооны хуралдаанаар Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн (МҮОНРТ)-иэс өөрийн нэмэлт сувгийн хөтөлбөрийг олон нийтэд хүргэх талаар ирүүлсэн хүсэлт болон талаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас ирүүлсэн саналын тухай танилцуулгыг хэлэлцээд, МҮОНРТ-ийн нэмэлт сувгуудын хөтөлбөрийг олон нийтэд хүргэхдээ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 1/259 дугаар албан тоотоор ирүүлсэн бодлогын удирдамж, чиглэлийг баримтлан хууль, тогтоомжийн дагуу зохицуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрээнд тусгах, албан тоотоор мэдэгдэх нь зүйтэй гэж шийдвэрлэв.
4. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 4 дүгээр хуралдааныг 2018 оны 4 дүгээр сарын 27-ны зохион байгуулсан. Энэхүү хорооны хуралдаанаар Монгол Улсын Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын 2017 оны жилийн эцсийн нэгдсэн статистик үзүүлэлт, тайлангийн тухай танилцуулга; Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлагын хэрэгжилтийг хангуулах тухай (Хорооны 2018 оны 04 дүгээр хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх); “ХХЗХ-ны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит”-ын талаар танилцуулга; тусгай зөвшөөрлийн талаар боловсруулсан санал дүгнэлт, тогтоолын төсөл; бусад асуудал (Сонгон шалгаруулалтыг хүчингүй болсонд тооцох тухай) зэрэг үндсэн 6 асуудлыг хэлэлцэж, хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 5 тогтоолыг батлан шийдвэрлэж, хэлэлцсэн зарим асуудлаар удирдамж, чиглэл бүхий хорооны хуралдааны 2 тэмдэглэлийг баталсан болно.
- Зохицуулах хороо нь хууль, тогтоомжийн хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт үйлчилгээ эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс /580 гаруй иргэн, хуулийн этгээд/ Үндэсний Статистикийн Хороо болон ХХЗХ-ны Даргын нарын хамтран баталсан 15 төрлийн маягтын дагуу хагас, бүтэн жилээр салбарын мэдээлэл, үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэн гаргаж, ЗГХЭГ, холбогдох яам, төрийн байгууллага, олон нийтэд тогтмол танилцуулж, дүн шинжилгээ хийж ирсэн. Уг статистик, үндсэн үзүүлэлтийн тайлан нь харилцаа холбооны салбарын нэвтрэлтийн тоон үзүүлэлт, нийт орлого, эдийн засгийн байдал, зах зээлийн тэлэлт, үйлчилгээний цар хүрээ, хэрэглээ, үйлчилгээний үнэ тарифийн өөрчлөлт, техник технологийн өнөөгийн байдлын талаар суурь судалгаатай болдог. Улмаар, салбарын урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө, бодлого чиглэл, зохицуулалтын баримт бичгүүд, төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, ОУЦХБ-д олон улсын жишиг маягтын дагуу нэгтгэн хүргүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Тус хуралдаанаар Монгол Улсын Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын 2017 оны жилийн эцсийн нэгдсэн статистик үзүүлэлт, тайлангийн тухай танилцуулгыг хэлэлцээд, ХХМТГ болон ҮСХ-тай хамтын ажиллагаа, үйл ажиллагаагаа улам



уялдуулах, зарим мэдээллийн маягт загварыг шинэчлэн сайжруулах, ОУЦХБ-д хүргүүлж байгаа статистик үзүүлэлтийг боловсруулах, тайлагнах талаар цаашид анхаарч ажиллахыг Зах зээл, үнэ тарифын үнэлгээ, судалгааны газарт үүрэг болгов (Дэлгэрэнгүй мэдээлэл татаж авах: <http://www.crc.gov.mn/k/35/4R>).

- Тус хуралдаанд Төрийн аудитын тухай хуулийн 15.1, 18.2 заалт, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийсэн тайлан, дүгнэлтийг үндэслэн “ХХЗХ-ны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит”-ын талаар танилцуулгыг хэлэлцүүлэв. Зохицуулах хорооны 2017 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн хувьд холбогдох хууль тогтоомж, журам зааврын дагуу “зөрчилгүй санал, дүгнэлт” гэж Аудитын гэрчилгээнд илэрхийлсэн байдал, аудиторын өгсөн санал, зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллахыг Төсвийн захирагч-д хуралдаанаас зөвлөмж болгосон байна.
- Тус хорооны 2018 оны ээлжит 4 дүгээр хуралдаанд, хорооны хуралдааны 2018 оны 04 дүгээр Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газраас “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлагын хэрэгжилтийг хангуулах тухай”, “Телевиз, сувгуудын зар сурталчилгааны хэтрэлт, авах арга хэмжээний санал”, хуралдааны тэмдэглэлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (холбогдох хууль тогтоомжоор хамаарал бүхий хуулийн этгээд нарт мониторинг, шалгалтын тайланг хүргүүлж, мэдэгдлийн хариуг албажуулан авсан, ирүүлсэн санал хүсэлт)-ний талаар танилцуулгыг авч хэлэлцээд, хорооны хуралдаанаас тодорхой удирдамж чиглэл бүхий хугацаатай үүрэг, даалгаврыг холбогдох газар, нэгжийн удирдлагад өгөх нь зүйтэй гэж тогтов. Тус хорооны хуралдааны 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 06 дугаар тэмдэглэлд, дээрх асуудлаар уг хуралдаанаас өгсөн үүрэг даалгавар, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, дүгнэлт болон холбогдох зохицуулалтын баримт бичиг, нөхцөл шаардлагад өөрчлөлт оруулах саналаа боловсруулан хорооны 2018 оны ээлжит 6 дугаар хуралдаанд танилцуулахыг Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар /С.Долгорсүрэн/-т үүрэг болгов.
- 2018 оны ээлжит 4 дүгээр хуралдаанаар баталсан 2018 оны 12, 13, 14, 15 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” 4 тогтоолын хавсралтаар:
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 22 иргэн, хуулийн этгээдэд 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 12 тоот тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрөл шинээр олгосон;



- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 13 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хамрах хүрээ болон радио давтамжийн зурваст өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дах заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалтыг тус тус үндэслэн 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 14 тоот тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 2 сараар түдгэлзүүлсэн;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1 дах заалт болон тухайн компаниудаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 15 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн болно.
- Зохицуулах хорооны 2018 оны ээлжит 1 дүгээр хуралдааны 01 дүгээр тэмдэглэлээр тодорхой шалтгааны улмаас бүрэн хэрэгжээгүй, хугацаа болоогүй хуралдааны тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх талаар санал боловсруулж, 2018 оны 1 дүгээр улиралд багтаан хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д үүрэг болгосон юм. Уг ажлыг хэрэгжүүлэх зорилгоор хорооны 2018 оны ээлжит 4 дүгээр дугаар хуралдаанд, "Сонгон шалгаруулалтыг хүчингүй болсонд тооцох тухай" (Хорооны 2015 оны 33 тоот) танилцуулга, тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлэв. Энэхүү асуудлын талаар тус хуралдаанаас Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам”-ын 4.4.1 дэх заалтыг үндэслэн хорооны 2015 оны 33 дугаар тогтоолоор зарласан “Тоон телевизийн үндэсний сүлжээгээр дамжуулах өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн үйлчилгээ эрхлэгч”-ийн сонгон шалгаруулалтын хүчинтэй байх хугацаа дууссан тул “Сонгон шалгаруулалтыг хүчингүй болсонд тооцох тухай” 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 16 дугаар тогтоолыг батлан шийдвэрлэв.
- Түүнчлэн хорооны 2018 оны ээлжит 4 дүгээр хуралдаанаар Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газраас нэгтгэн боловсруулсан нэр бүхий 4 хуулийн этгээдийн “Тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулах тухай” танилцуулга, үнэлгээний дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцээд, Хүннү ХХК болон Сүлд медиа ХХК-ийн Монгол



Улсын нутаг дэвсгэрт “Кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт “Телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл болгон өөрчлөлт оруулах асуудлыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас дээрх тусгай зөвшөөрлийн талаар бодлогын чиглэл гарсаны дараа шийдвэрлэх нь зүйтэй гэж тогтож, хорооны 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэлийг гаргасан болно.

5. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 5 дугаар хуралдааныг 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав. Тус хорооны ээлжит хуралдаанаар “Олон сувгийг олон цэгт түгээх системд ашиглах радио давтамжийн зурвас хуваарилах, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тогтоож батлах тухай; Хорооны 2017 оны 31 тоот тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл (Нэмэлт: “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага); “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д нэмэлт оруулах тухай (Хорооны 2018 оны 06 дугаар хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх); “ХХЗХ-ны найдваргүй авлагын нөөцийн сан байгуулах журам”-ын төслийн танилцуулга; тусгай зөвшөөрлийн талаар боловсруулсан санал дүгнэлт, тогтоолын төсөл зэрэг үндсэн 5 асуудлыг хэлэлцэж, хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 6 тогтоолыг батлан шийдвэрлэж, хэлэлцсэн зарим асуудлаар удирдамж, чиглэл бүхий хорооны хуралдааны 2 тэмдэглэлийг баталсан болно.
  - Харилцаа холбооны зохицуулах хорооны 2013 оны 29 дүгээр “Давтамжийн зурвас хуваарилах тухай” тогтоолын 3 дугаар хавсралт; 2016 оны 13 дугаар “Шинэчлэн батлах, хүчингүй болгох тухай тогтоолын 3 дугаар хавсралтын 4 дэх заалтын хүрээнд олон сувгийг олон цэгт түгээх системийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоон хэрэгжүүлж байгаа юм. Эдгээр баримт бичгийг ХЗДХЯ-д хүргүүлэн санал зөвлөмжийг албан тоотоор авсан болно. Тус яамны зөвлөмжид “Харилцаа холбооны зохицуулах хороонд Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.10 дахь заалтуудаар радио давтамжийн зурвасын хуваарилалт болон харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох бүрэн эрхийг олгосон тул энэхүү эрх олгосон заалтын хүрээнд нийцүүлж, баримт бичгүүдийг шинэчлэн баталж, Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.5 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэн мөрдөх нь зүйтэй гэж үзэж байна.” гэсэн юм. Иймээс тус яамнаас ирүүлсэн зөвлөмж, Захиргааны ерөнхий хуульд баримт бичгийг нийцүүлэх зорилгоор Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газар болон Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар хамтран дээрх 2 тогтоолыг нэгтгэн “Олон сувгийг олон цэгт түгээх системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын төсөл, танилцуулга, тогтоолын төслийг боловсруулжээ. Тус хуралдаанаар энэхүү асуудлыг авч хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Радио



давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай” 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 17 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар “Олон сувгийг олон цэгт түгээх системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг батлан шийдвэрлэсэн. Энэхүү баримт бичгийг баталснаар Дэлхийн радиогийн их хурлаас баталсан Олон улсын радио давтамжийн дүрэм, Монгол улсын “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийг олон сувгийг олон цэгт түгээх системд ашиглах 2200-2300, 2700-2900 МГц-ийн зурвасыг хуваарилах, радио давтамжийг үр дүнтэй ашиглах техникийн нөхцөл, шаардлагыг тодорхойлж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2013 оны 29 дүгээр тогтоол, 2016 оны 13 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “Шинэчлэн баталсан баримт бичгийн жагсаалт”-ын “3.Монгол Улсад 2200-2300 МГц давтамжийн зурвасын зохицуулалтын чиглэл” -ийг тус тус хүчингүй болгов. Уг тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлж, 2018 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөр бүртгэлийн сангийн 3950 дугаарт бүртгүүлэв.

- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 31 дүгээр тогтоолоор баталсан “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3782 дугаарт бүртгүүлэн мөрдөж байгаа болно. Тус баримт бичгийн 1 дүгээр хавсралтад “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тодорхойлогдсон давтамжийн нийт зурвасын хуваарилалт”-ын дагуу радио давтамжийн зурвасуудыг хуваарилсан ба “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д радио сувгийн хуваарилалтыг 450-470 МГц-ын давтамжийн зурваст хийгдээгүй байсан болно. Иймээс Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 31 дүгээр тогтоолоор баталсан “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын баримт бичигт радио сувгийн зохион байгуулалт, суваг үүсгэх томьёолол, олгох сувгийн тоо, өргөн болон “Радио давтамжийн 450-470 МГц-ийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-ыг нэмэлтээр оруулан шийдвэрлэх талаар танилцуулга, тогтоолын төслийг боловсруулсан. Хорооны ээлжит 5 дугаар хуралдаанаар хорооны 2017 оны 31 тоот тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл, баримт бичгийн танилцуулга, “Радио давтамжийн 450-470 МГц-ийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага”-ын төслийг тус тус хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дах заалт, 9.1.10 дах заалт, Радио долгионы тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагад нэмэлт оруулах тухай” 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 18 тоот тогтоолыг баталж, энэхүү тогтоолоор Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 31 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 2 дугаар хавсралтад оруулах нэмэлтийг



тогтоолын Нэгдүгээр, 7 дугаар хавсралтаар оруулах нэмэлтийг тогтоолын Хоёрдугаар хавсралт дагуу тус тус нэмэлтээр оруулсан.

- Тус хорооны 2018 оны ээлжит 5 дугаар хуралдаанд, хорооны 2018 оны хуралдааны 06 дүгээр Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газраас “Телевиз, сувгуудын зар сурталчилгааны хэтрэлт, авах арга хэмжээний санал”-ын төсөл, холбогдуулан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-д нэмэлт оруулах тухай асуудлыг боловсруулан хэлэлцүүлэв. Энэхүү асуудлыг хуралдаанаар авч хэлэлцээд, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дах заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4, 5.3.7 дах заалтыг тус тус үндэслэн “Зохицуулалт, нөхцөл шаардлагад нэмэлт оруулах тухай” 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 19 тоот тогтоолыг батлав. Уг тогтоолд, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 15 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ын 7 дугаар зүйлийн 7.27-д “Нэг цагт дамжуулах зар сурталчилгааны хэтрэлтийн зөрчлийг тооцохдоо 18:00-23:59 цагийн хооронд дамжуулсан хөтөлбөрт эзлэх хэтрэлтийн нийт цагийг авч үзнэ” гэж нэмэлт оруулсан ба энэхүү тогтоолын нэмэлтийг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн болно. Түүнчлэн зохицуулалт, нөхцөл шаардлагад нэмэлт оруулсантай холбогдуулан өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгуудтай байгуулсан болон байгуулах тусгай зөвшөөрлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт үүрэг болгов.
- Тус хуралдаанд “ХХЗХ-ны найдваргүй авлагын нөөцийн сан байгуулах журам”-ын төслийн танилцуулгыг авч хэлэлцээд, журмын төслийн зарим заалтыг боловсронгуй болгох, эрх зүйн орчин, эрх олгогдсон эсэх, ижил төстэй байгууллагын талаар судлан боловсруулан Хорооны дараагийн ээлжит хуралдаанд танилцуулахыг 2018 оны 8 дугаар хуралдааны тэмдэглэлээр ЗУХАГ-ын дарга-д үүрэг болгов.
- 2018 оны ээлжит 5 дугаар хуралдаанаар баталсан 2018 оны 20, 21, 22 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” 3 тогтоолын хавсралтаар:
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 16 ААН, хуулийн этгээдэд 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 20 тоот тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн





- журам"-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 21 тоот хавсралтаар 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд нэмэлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 12.1.1 дах заалт болон тухайн компаниудаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 22 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн болно.
  - Хуралдааны үеэр хорооны нэр бүхий гишүүдээс гаргасан саналын дагуу хорооны чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд үзүүлж байгаа тусгай зөвшөөрлийн үйлчилгээний талаар судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэлт, зөвшөөрлийн насжилт, нөхцөл шаардлагын хэрэгжилт, зөвшөөрлийн талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал зэрэг асуудлыг боловсруулан Хорооны дараагийн ээлжит хуралдаанд танилцуулахыг 2018 оны 9 дүгээр хуралдааны тэмдэглэлээр ЗУХАГ-ын дарга-д үүрэг болгов.
6. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 6 дугаар хуралдааныг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулав. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 6 дугаар хуралдаанаар "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын төслийн тухай; "Тоон радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын төслийн тухай; ХХЗХ-ны найдваргүй авлагын нөөцийг бүрдүүлэх талаар танилцуулга (Хорооны 2018 оны 08 дугаар хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх); Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай (Тооллогын ажлын хэсэг); тусгай зөвшөөрлийн талаар боловсруулсан танилцуулга, санал дүгнэлт, тогтоолын төсөл зэрэг үндсэн 5 асуудлыг хэлэлцлээ. Энэхүү хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 6 тогтоолыг батлан шийдвэрлэж, удирдамж чиглэл болон баталсан тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай хорооны хуралдааны 2 тэмдэглэлийг гаргалаа.
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дэх заалтад "харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох, баталгаажуулах"; мөн 9.1.10 дах заалтаар "радио давтамжийн зурвасыг хуваарилах, хяналт тавих" гэсэн заалтын дагуу Харилцаа холбооны зохицуулах хороонд радио давтамжийг хуваарилах, хяналт тавих болон техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох бүрэн эрх олгогдсон байдаг болно. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 68 тоот тогтоолоор "Монгол Улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах зохицуулалт"-ыг баталсан бөгөөд хүчин төгөлдөр мөрдөж байгаа билээ. Гэвч үүрэн холбооны техник технологийн дэвшил, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч нараас ирүүлсэн санал,



хүсэлт, хуулийн зөвлөх үйлчилгээний зөвлөмж, дүгнэлтээр энэхүү баримт бичгийг шинэчлэн батлах шаардлага гарч ирсэн юм. Хуулийн зөвлөх үйлчилгээний зөвлөмжид, “Бичилтийн болон тогтоолын тэмдэглэх хэсэгт үндэслэсэн хуулийн заалтыг орхигдуулсныг залруулан Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.10 дахь заалтуудыг үндэслэн эрх олгосон заалтын агуулга, хүрээнд багтаан радио давтамжийн зурвасын ашиглалт, үйлчилгээний чиглэл, стратеги нь хуваарилалт гэдэг дотор багтаж байгааг энгийнээр найруулах, давтамжийн сувгийг олгоход тавигдах нөхцөл, шаардлага гэснийг давтамжийн сувгийн нөхцөл шаардлага гэх зэргээр хуулиар эрх олгосон заалтын томъёолол, агуулгад нийцүүлэн өөрчлөн найруулах нь зүйтэй байна. ....Тогтоол баталсан үндэслэл хэсгийн Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн заалтын нь 2016 онд шинэчлэгдэн өөр болсон..., ... Баталсан баримт бичгийн агуулгаас харвал Дараа үеийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагыг тодорхойлсон гэж ойлгохоор байгаа ч хуулиар эрх олгосон заалт болох Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.10 дахь заалтын агуулга, хүрээнээс хальсан нэр томъёоны тодорхойлолт, тусгай зөвшөөрөл олгох, радио давтамж ашиглах үйлчилгээ эрхлэх эрхийн төлбөр зэрэг зохицуулалтыг агуулсан нь Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасан эрх олгосон хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх шаардлагыг хангаагүй байна..” гэсэн байна. Захиргааны ерөнхий хуульд уг баримт бичгийг нийцүүлэх, хуулийн зөвлөх үйлчилгээний зөвлөмж дүгнэлт, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч нараас ирүүлсэн санал, уулзалт хэлэлцүүлгийн үр дүн, ШӨХТГ-ын саналыг тус тус харгалзан Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газар, Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар хамтран “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тогтоож, батлах тухай хорооны тогтоолын төсөл, танилцуулга, саналын товчоо, шинэчилсэн хавсралт баримт бичгийн төслийг тус тус боловсруулан хуралдаанд хэлэлцүүлсэн болно. Тус хуралдаанаар энэхүү асуудлыг авч хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дэх заалт, 9.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай” хорооны хуралдааны 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 23 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг батлан шийдвэрлэв. Энэхүү баримт бичгийг шинэчлэн баталснаар Дэлхийн Радиогийн их хурлаас баталсан “Олон улсын радио давтамжийн дүрэм”, Монгол Улсын “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийн дагуу Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасыг хуваарилах, холбогдох техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох, уг баримт бичгийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, радио зурвасыг үр ашигтай ашиглах нөхцөл, хяналтын арга хэмжээг бүрдүүлэх боломжтой болсон. Энэхүү тогтоолыг баталснаар тус хорооны 2007 оны 61 дүгээр тогтоол, 2008 оны 18 дугаар тогтоол, 2013 оны 46 дугаар тогтоол, 2015 оны 68 дугаар тогтоол, 2017



оны 09 дүгээр тогтоол, 2017 оны 10 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгов. Тус хорооны 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 23 тоот тогтоол батлагдсантай холбогдуулан “Хорооны 2018 оны 23 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” удирдамж, чиглэл бүхий 2018 оны 10 дугаар хуралдааны тэмдэглэлийг гаргалаа. Уг тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санд 3952 дугаарт 2018 оны 6 дугаар сард бүртгүүлэв.

- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2016 оны 30 дугаар тогтоолын хавсралтаар “Радио өргөн нэвтрүүлгийн аналог системийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах зохицуулалт”-ыг баталсан бөгөөд энэхүү баримт бичгийг Захиргааны ерөнхий хууль нийцүүлэх, тоон радио өргөн нэвтрүүлэг ба технологийг нэвтрүүлэх, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Даргын 2017 оны А/71 тоот тушаалаар баталсан “Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах чиглэл”-ийн зорилт, заалтыг хэрэгжүүлэх шаардлага гарч ирсэн болно. Хуулийн зөвлөх үйлчилгээний зөвлөмжид “Тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай хуулийн нэр томъёо, эрх олгосон заалтын агуулга, хүрээнд нийцүүлэн шинэчлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан бүрдлийг ханган Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хянуулж, бүртгүүлэн мөрдөх нь зүйтэй гэж үзэж байна.” Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газар, Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газраас хамтран боловсруулсан “Тоон радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын төсөл, танилцуулга болон хорооны тогтоолын төслийг тус тус хуралдаанаар авч хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дэх заалт, 9.1.10 дах заалтыг тус тус үндэслэн 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 24 тоот “Тоон радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай” хорооны хуралдааны тогтоолыг батлав. Энэхүү тогтоолын хавсралтаар “Тоон радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг батлан шийдвэрлэсэн ба Дэлхийн Радиогийн их хурлаас баталсан “Олон улсын радио давтамжийн дүрэм”, “Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах чиглэл”, Монгол Улсын “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийг тус тус үндэслэн тоон радио өргөн нэвтрүүлгийн (DAB+) технологид ашиглах радио давтамжийн зурвасыг хуваарилах, радио давтамжийг үр дүнтэй ашиглах техникийн нөхцөл, шаардлагыг тодорхойлжээ. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2016 оны 30 дугаар тогтоолыг хүчингүй болгов. Энэхүү 2018 оны 24 тоот тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санд бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд хүргүүлж, улсын бүртгэлийн 3953 дугаарт бүртгүүлээд байна.
- Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны Даргын 2017 оны А/259 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс тус хорооны эд хөрөнгийн үзлэг, тооллогыг Төрийн



болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журмын дагуу зохион байгуулж, актлах хөрөнгийн жагсаалтын төслийг боловсруулжээ. Ажлын хэсгээс тооллогын явцад ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн үндсэн хөрөнгөөс сэргээн засварлаж, цаашид байгууллагын хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй болсон үнэ бүхий үндсэн хөрөнгийг илрүүлэн актлах саналын талаар танилцуулга, актлах хөрөнгийн жагсаалт, тогтоолын төслийг боловсруулан тус тус Хорооны хуралдаанд хэлэлцүүлэв. Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам” болон 2017 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн “Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай” хорооны хуралдааны 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 25, 26 тоот тогтоолыг тус тус батлав. Тогтоолын хавсралтаар баталсан нэр бүхий ашиглалтын хугацаа дууссан хэрэгцээ хангахгүй болсон машин, тоног төхөөрөмжийг; тавилга, эд хогшлыг; программ хангамжийг; ашиглалтын хугацаа дуусч, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, сэргээн засварлахад өртөг өндөртэй, цаашид байгууллагын хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй болсон авто тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгөнөөс хасч актлах, устгах саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэхээр тогтов.

- 2018 оны ээлжит 6 дугаар хуралдаанаар баталсан 2018 оны 27, 28 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” нийт 2 тогтоолын хавсралтаар:
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 8 ААН, хуулийн этгээдэд 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 27 тоот тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1 дах заалт болон компаниас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 28 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн.
- Тус хуралдаанаар хорооны 2018 оны 08 дугаар тэмдэглэлээр өгсөн удирдамж чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗУХАГ-аас шинэчлэн



боловсруулсан “ХХЗХ-ны найдваргүй авлагын нөөцийн бүрдүүлэх тухай”-ын танилцуулга, холбогдох журмын төсөл, хуралдааны тэмдэглэлийн төслийг тус тус авч хэлэлцээд, “Харилцаа холбооны зохицуулах хорооны найдваргүй авлагын нөөц байгуулах журам”-ын төслийг зарчмын хувьд дэмжиж, энэхүү журмыг Хорооны даргын тушаалаар батлах нь зүйтэй гэж тогтов. Зохицуулах хорооны найдваргүй авлагын нөөцийн бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, журмын дагуу холбогдох асуудлыг тухай бүр боловсруулан Хорооны хуралдаанаар шийдвэрлүүлж ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт 2018 оны хорооны хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр үүрэг болгов.

7. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 7 дугаар хуралдааныг 2018 оны 7 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулсан. Энэхүү хуралдаанаар “Жемнэт ХХК-ийн интернэтийн бөөний үйлчилгээний үнэ тариф батлах” тухай тогтоолын төсөл (Хорооны 2018 оны 03 дугаар хуралдааны тэмдэглэлээр удирдамж, чиглэлийг холбогдох газар хэлтэст өгч, дахин боловсруулж Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр үүрэг болгосон); тусгай зөвшөөрлийн талаар боловсруулсан танилцуулга, санал дүгнэлт, тогтоолын төсөл бүхий 2 асуудлыг хэлэлцсэн болно. Энэхүү хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 4 тогтоолыг батлан шийдвэрлэсэн.
  - Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.5 дахь хэсэгт “харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах”, мөн хуулийн 9.1.6-д “харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх” тухай заасныг үндэслэн ШӨХТГ-ын шийдвэрээр интернетийн бөөний урсгалын үйлчилгээний зах зээлд давамгайл байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдсон “Жемнет ХХК”-ийн үйлчилгээний үнэ тарифид зохицуулалт хийх тухай санал, таницуулгыг 2018 оны ээлжит 3 дугаар хуралдаанд хэлэлцүүлсэн бөгөөд тус хорооны “Үнэ тарифын талаар авах арга хэмжээний тухай” 2018 оны 03 дугаар хуралдааны Тэмдэглэлээр хорооны нэр бүхий гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийн дагуу холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд эрх ашиг нь хөндөгдсөн тухайн компанид хүргүүлэн саналыг албан ёсоор авч Хорооны хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзсэн билээ. Уг тэмдэглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу Зохиццлах хорооноос “Үнэ тарифын санал хүргүүлэх тухай” албан бичгийг 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр 05/510 тоотор “Жемнет ХХК-д хүргүүлж, Жемнэт ХХК-иас 2018 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн 18/112 тоот албан бичгээр тус компани гадаадын харилцагч байгууллагуудтай байгуулсан үйлчилгээний гэрээг шинэчлэн байгуулсан, технологийн шинэчлэлтийг хийж байгаатай холбогдуулан интернетийн бөөний үйлчилгээний 1Мб/сек хурдтай урсгалын үнэ тарифын саналын хариуг ирүүлсэн. Түүнчлэн Харилцаа холбооны зохицуулах хорооноос “Жемнэт ХХК”-ийн интернэтийн бөөний үйлчилгээний үнэ тарифид зохицуулалт хийх талаар Жемнет ХХК-тай 2 удаа, Мобиком нетворкс ХХК-тай 1 удаа уулзалтыг тус тус зохион байгуулсан болно.



- Тус хорооны 2018 оны ээлжит 7 дугаар хуралдаанаар Жемнет ХХК-ийн “Дотоодод борлуулах интернетийн бөөний урсгалын үйлчилгээний доод үнэ ”-ийн зохицуулалтын талаар танилцуулга, эрх ашиг нь хөндөгдөж буй хуулийн этгээд нарт мэдэгдэж, ирүүлсэн саналын тухай, үнэ тариф батлах тухай хорооны тогтоолын төслийг тус тус боловсруулан хэлэлцүүлэв. Хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах заалтыг үндэслэн 2018 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн “Үнэ тариф тогтоох тухай” 29 дугаар тогтоолыг баталж, интернетийн бөөний урсгалын үйлчилгээний зах зээлд давамгайл байдалтай аж ахуйн нэгж болох Жемнет ХХК-ийн “Дотоодод борлуулах интернетийн урсгалын бөөний үйлчилгээний доод үнэ”-ийг тогтоолын хавсралтад заасан хэмжээгээр тогтоож шийдвэрлэв.
- Хорооны 2018 оны ээлжит 7 дугаар хуралдаанаар баталсан 2018 оны 30, 31, 32 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” нийт 3 тогтоолын хавсралтаар:
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 9 ААН, хуулийн этгээдэд 2018 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 29 тоот тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалт, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2018 оны 4/607 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийг тус тус үндэслэн 2018 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 31 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 15.1.3 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1, 12.1.4, 12.1.6 дах заалт тус тус үндэслэн 2018 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 32 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдийн 8 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн.



8. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 8 дугаар хуралдаан 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдөр болов. Уг хуралдаанаар Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын талаар танилцуулга (Хорооны 2018 оны 09 дүгээр хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх); “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт оруулах тухай (Хорооны 2016 оны 13 дугаар тогтоол, 2017 оны 42 тоот тогтоол); “Харилцаа холбооны богино зайн радио холбооны тоног төхөөрөмжийн радио давтамжийн зурвасын зохицуулалт, техникийн нөхцөл шаардлага”-д нэмэлт оруулах тухай (Хорооны 2017 оны 44 тоот тогтоол); тогтоол хүчингүй болгох тухай (Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, хэрэгжүүлэх); тусгай зөвшөөрлийн талаар боловсруулсан танилцуулга, санал дүгнэлт, тогтоолын төсөл; Бусад асуудал (Танилцуулга: РДХЗГ-аас Улаанбаатар хот, Зүүн бүсийн аймгууд, Төв, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн ААН-д хийсэн 3 хэмжилт, хяналт шалгалтын тайлан, санал дүгнэлт; Цахим орчин, өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын хүрээнд ХХЗХ-ноос Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан; ОУЦХБ-ын цахилгаан соронзон орны заавар (ITU EMF Guide), хүний биед үзүүлэх нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлэл түгээх гар утасны аппликэйшн-ны тухай) зэрэг нийт 10 асуудлыг хэлэлцсэн болно. Энэхүү хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 7 тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.
- Тус хорооны 2018 оны ээлжит 8 дүгээр хуралдаанд, хорооны 2018 оны хуралдааны 09 дүгээр Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газраас “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” танилцуулгыг хийлээ. Хуралдаанаар танилцуулгыг хэлэлцэх явцад хорооны нэр бүхий гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийн дагуу өргөн нэвтрүүлгийн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар саналаа боловсруулан 2018 оны ээлжит хуралдаанд хэлэлцүүлэхийг үүрэг болгов.
  - Зохицуулах хорооны 2017 оны 42, 44 тоот тогтоолыг ХЗДХЯ-нд хүргүүлэн хянуулах явцад ХЗДХЯ-ны 2017 оны 1-1/3781 албан тоотоор ХХЗХ-нд зөвлөмж ирүүлсэн ба энэхүү зөвлөмжид “Харилцаа холбооны зохицуулах хороонд Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.10 дахь заалтуудаар радио давтамжийн зурвасын хуваарилалт болон харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох бүрэн эрхийг олгосон тул энэхүү эрх олгосон заалтын хүрээнд нийцүүлж, тогтоолын хавсралт баримт бичгийг шинэчлэн баталж, Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.5 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэн мөрдөх нь зүйтэй” гэж үзсэн байна. Иймээс ХЗДХЯ-ны ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газар болон Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар нь 2017 оны 42 дугаар тогтоол болон 2016 оны 13 дугаар тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, 2017 оны 42 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт оруулах танилцуулга, тогтоолын төсөл, нэмэлт оруулах төслийг боловсруулсан. Тус хорооны



хуралдаанаар энэхүү асуудлыг авч хэлэлцээд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дэх заалт, 9.1.10 дах заалтуудыг тус тус үндэслэн 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн “Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагад нэмэлт оруулах тухай” 33 тоот тогтоолыг батлахаар шийдвэрлэж, хорооны 2017 оны 42 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр хавсралтад оруулах нэмэлтийг уг тогтоолын Нэгдүгээр хавсралт, 3 дугаар хавсралтад оруулах нэмэлтийг тогтоолын Хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсан болно. Тогтоолын хавсралтыг баталснаар “Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д нэмэлтээр хяналт хийх заалтууд, радио давтамжийн 1164-1215 МГц, 1240-1300 МГц, 1350-1400 МГц, 2025-2100МГц-ийн зурваст ажиллах тоон радио релейний станцын зурвасын хуваарилалт, техникийн болон ашиглалтын шаардлагыг шинээр тодорхойлжээ. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2016 оны 13 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтын 2 дах хэсгийг хүчингүй болгов.

- Түүнчлэн зохицуулах хорооны 2018 оны ээлжит 8 дугаар хуралдаанаар тус хорооны 2017 оны 44 тоот тогтоолын талаар ХЗДХЯ-наас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх, тогтоолын хавсралтад нэмэлт оруулах танилцуулга, тогтоолын төсөл, нэмэлтээр оруулах баримт бичгийн төслийг боловсруулан хэлэлцүүлсэн ба Хорооны 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн “Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагад нэмэлт оруулах тухай” 34 тоот тогтоолыг хавсралтын хамт баталсан. Уг тогтоолд, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дэх заалт, 9.1.10 дах заалтуудыг тус тус үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 44 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны богино зайн радио холбооны тоног төхөөрөмжинд ашиглах радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр хавсралтад оруулах нэмэлтийг тогтоолын Нэгдүгээр, 14 дүгээр хавсралтаар оруулах нэмэлтийг энэхүү тогтоолын Хоёрдугаар хавсралт дагуу тус тус батлав. Тогтоолд нэмэлт оруулснаар ультра өргөн зурвасын (UWB) төхөөрөмжийн техникийн шаардлагыг шинээр тодорхойлон баталсан бөгөөд энэ төрлийн төхөөрөмж нь саадыг нэвтэрч гарах, газрын түвшнээс доош тандах радар, автомашины радар, байршил тогтоогч, тракинг, хиймэл дагуулын линк, тандан судалгааны хиймэл дагуулын системийн идэвхигүй мэдрэгч, радио астрономийн станц зэрэгт өргөнөөр ашигладаг.
- Тус хорооноос Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль, тогтоомжид хорооны тогтоол, шийдвэрийг нийцүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү арга хэмжээний хүрээнд 2002 оноос хорооны хуралдаанаар баталсан 180 гаруй тогтоол, нэмэлт өөрчлөлтийг хянан үзэж, ЗЕХ-д нийцүүлэн батлах, хүчингүй болгох, баталсан тогтоол шийдвэрийг ХЗДХЯ-д хүргүүлэн хянуулж, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд бүртгүүлж байна. Бүртгүүлсэн хорооны тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ([www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)), хорооны цахим хуудас ([www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn))-д тус тус байршуулж байгаа билээ. ЗУХАГ-аас Захиргааны





ерөнхий хуульд нийцээгүй, хуулиар журам гаргах эрх олгоогүй, үйлчлэх хугацаа дууссан, гинэчлэн батлах шаардлагатай журам, нөхцөл шаардлага, нэмэлт өөрчлөлтийг оруулж баталсан, дотооддоо Даргын тушаалаар батлан мөрдөх боломжтой зарим зохицуулалтын баримт бичгүүд, холбогдох хорооны тогтоолын судалгааг гаргаж, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн явцыг нэгтгэн хорооны 2018 оны ээлжит 8 дугаар хуралдаанд хэлэлцүүлэв. Энэхүү асуудлаар хорооны 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн “Тогтоол хүчингүй болгох тухай” 35 тоот тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн 49.1 дэх заалтыг үндэслэн баталсан. Тогтоолоор тус хорооны баталсан зарим журам, нөхцөл шаардлага, зохицуулалтын бичиг баримт, хуваарилалт болон холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан хорооны 8 тогтоолыг хавсралтын хамт хүчингүй болгон шийдвэрлэв.

- Тус хорооны Радио давтамж зохицуулалт, хяналтын газар, ШУТИС-ийн МХТС-тай хамтран ОУЦХБ-ын цахилгаан соронзон орны зааварыг (ITU-EMF Guide) орчуулж, Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох үндэсний стандарт, холбогдох дүрэм журам, баримт бичгийг тусган хүний биед цахилгаан соронзон орны үзүүлэх нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлэл түгээх гар утасны аппликэйшн боловсруулжээ. Уг аппликэйшн нь цахилгаан соронзон орны хүний биед үзүүлэх үр нөлөөний талаар олон нийт, хэрэглэгч нарт үнэн зөв мэдээлэл болон мэдлэг түгээх, аппликэйшний тусламжтайгаар техник технологийн зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх, түүнээс гарч байгаа эерэг, сөрөг нөлөөллийг аппликэйшн хэлбэрээр зөвлөмж болгон хүргэх зорилготой юм. Хуралдаанаар энэхүү аппликэйшн хөгжүүлсэн төслийн тайлан, хэрэглээний талаар танилцуулгыг авч хэлэлцээд, аппликэйшнийг иж бүрнээр нь хөгжүүлэн бүрэн дуусгаж, гар утасны хэрэглээнд нэвтрүүлэх, сурталчилах талаар удирдамж, чиглэл өглөө.
- Хорооны 2018 оны ээлжит 8 дугаар хуралдаанаар баталсан 2018 оны 36, 37, 38, 39 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл сэргээх тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” нийт 4 тогтоолын хавсралтаар:
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 10 ААН, хуулийн этгээдэд 2018 оны 8 дугаар сарын 31-ны өдрийн 36 тоот тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот



- тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 37 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дах заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дох заалтыг тус тус үндэслэн 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 38 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1 дах заалт болон иргэн Г.Дөлгөөнөөс ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн 2018 оны 8 дугаар сарын 31-ны өдрийн 39 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн.
- Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газраас цахим орчин, өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын хүрээнд “ХХЗХ-ноос Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар 2017-2018 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан”-г хорооны 2018 оны ээлжит 8 дугаар хуралдаанд танилцуулав. Хорооны хуралдаанаас ХХЗХ-ноос хийж гүйцэтгэсэн ажлын талаар үнэлэлт дүгнэлт өгч, ажлаа эрчимжүүлэх, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах, гүйцэтгэсэн ажлын хүрсэн үр дүн ач холбогдлыг сурталчилах, тайланд тусгасан төсөл, арга хэмжээний үр дүнг нэгтгэн УИХ-ын Байнгийн хороо, ЗГХЭГ, ХЗДХЯ-нд тайлагнах, хүргүүлэх нь зүйтэй гэж тогтов.
9. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 9 дүгээр хуралдааныг 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулав. Хуралдаанаар тусгай зөвшөөрлийн талаар боловсруулсан танилцуулга, санал дүгнэлт, тогтоолын төслийг авч хэлэлцсэн. Уг хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 3 тогтоолыг батлан шийдвэрлэв.
- Хорооны 2018 оны ээлжит 9 дүгээр хуралдаанаар баталсан 2018 оны 40, 41, 42 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” нийт 3 тогтоолын хавсралтаар:
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх



- зөвшөөрлийн журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 3 ААН, хуулийн этгээдэд 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 40 тоот тогтоолын хавсралтаар тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 41 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1 дах заалт болон ДДэштв ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 42 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн.
10. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 10 дугаар хуралдааныг 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулав. Тус хуралдаанаар тусгай зөвшөөрлийн талаар боловсруулсан танилцуулга, санал дүгнэлт, тогтоолын төсөл, бусад асуудал (“Хорооны хуралдааны урамшууллын хэмжээ”-г тогтоох тухай) авч хэлэлцсэн. Энэхүү хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 1 тогтоолыг батлан шийдвэрлэв.
- Зохицуулах хорооны хуралдаанд хэлэлцсэн тусгай зөвшөөрлийн талаар боловсруулсан танилцуулга, санал дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэв. Хуралдаанаас тусгай зөвшөөрлийн асуудлыг хэлэлцэх үеэр хорооны гишүүдээс гарсан санал, зөвлөмжийн дагуу холбогдох судалгаа, тооцоог боловсруулан нэгтгэж дараагийн ээлжит хуралдаанаар хэлэлцэхээр түр хойшлуулав.
  - Тус хуралдаанаар хорооны хуралдааны урамшууллын хэмжээ тогтоох тухай танилцуулга, тогтоолын төслийг авч хэлэлцээд, Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.3 дах заалтыг үндэслэн зохицуулах хорооны дарга, хорооны гишүүдэд олгох хуралдааны урамшууллын цагийн хэмжээг тогтоож, хорооны 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн “Хорооны хуралдааны урамшууллын хэмжээг тогтоох тухай” 43 тоот тогтоолыг батлав. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2016 оны 44 тоот тогтоолыг хүчингүй болгов.



11. Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны ээлжит 11 дүгээр хуралдаан 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болов. Энэхүү хуралдаанаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон төсвийн гүйцэтгэл”-ийн талаар танилцуулга; “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл ба төсвийн төсөл”-ийн тухай танилцуулга; Шуудангийн үнэ тарифын тухай; Тусгай зөвшөөрлийн өр авлагын талаар танилцуулга (Дансны авлагын дүнгээс хасч залруулах тухай); тусгай зөвшөөрлийн талаар боловсруулсан танилцуулга, санал дүгнэлт, тогтоолын төслүүдийг хэлэлцсэн. Уг хуралдаан нь хэлэлцсэн асуудлаар хорооны хуралдааны 3 тогтоолыг батлан шийдвэрлэв.

- Тус хуралдаанаар Шуудангийн тухай хуулийн 18.2 дахь хэсэг болон Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах хэсгийг үндэслэн шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээний зах зээл, Хот хоорондын шуудангийн үйлчилгээний зах зээлүүдэд давамгайл байдалтай аж ахуйн нэгжээр тогтоогдсон Монгол Шуудан ХК-ийн дотоодын шуудангийн үйлчилгээний дээд, доод үнэ (НӨАТ ороогүй)-ийг тогтоож батлах талаар танилцуулга, тогтоолын төслийг авч хэлэлцлээ. Тус хуралдаанаас өгсөн удирдамж, зөвлөмжийн дагуу холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зах зээлийн шинэ орчин үүссэн, хувьчлагдсан компани болсон нөхцөл, байдлыг дахин нягтлан судлах, төрийн болон хувийн хэвшлийн ААН, байгууллагын төсөв зардал нэмэгдэх судалгаа тооцоог гаргах, эрх ашиг нь хөндөгдөж буй тухайн компанид хүргүүлэн саналыг албан ёсоор авч асуудлыг боловсруулж, Хорооны 2019 оны 1 дүгээр улиралд багтаан хэлэлцүүлэхийг Зах зээл, үнэ, тарифын үнэлгээ, судалгааны газар, Шуудангийн зохицуулалтын газарт тус тус үүрэг болгосон Хорооны хуралдааны “Шуудангийн үйлчилгээний үнэ тарифын тухай” 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 12 дугаар тэмдэглэлийг гаргаж, удирдамж чиглэлэ өгсөн болно.
- ХХЗХ-ны Даргын 2018 оны А223 тоот тушаалын хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газраас боловсруулсан “Дансны авлагын дүнгээс хасаж залруулах зөвшөөрлийн жагсаалт”-ын танилцуулга, хуралдааны тэмдэглэлийн төсөл, хавсралт жагсаалтыг хэлэлцээд, хорооны хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 12 дугаар “Тусгай зөвшөөрлийн гэрээний нөхцөл шаардлага, хэрэгжилтийг хангуулах тухай” тэмдэглэлийг батлахаар тогтов. Уг тэмдэглэлд, тусгай зөвшөөрлийн гэрээний нөхцөл, шаардлагыг биелүүлээгүй, өр төлбөртэй ААН, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт холбогдох хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэв. Дээр заасан зөрчилтэй, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлэхгүй байгаа тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчдийн тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээг сунгахгүй байх тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх, шинэ зөвшөөрөл олгох асуудлыг зөрчлөө бүрэн арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх, өр төлбөртэй, зөрчилтэй тусгай зөвшөөрөл эзэмшигчийг Хорооноос зарлах аливаа тендер, сонгон шалгаруулалтад оролцуулахгүй байх талаар тендер, сонгон



шалгаруулалтын баримт бичигт тухай бүр тусгах асуудлыг шийдвэрлэх, энэ зүйлд заасан асуудлаар холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд анхааруулга, албан мэдэгдэл хүргүүлж, Хорооны хуралдаанд тухай бүр тайлагнаж ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт тус тус үүрэг болгов. Энэхүү хэлэлцсэн асуудлаар “Дансны авлагын талаар авах арга хэмжээний тухай” 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл гаргахаар шийдвэрлэв. Энэхүү хуралдааны тэмдэглэлийн хавсралтаар “Өнгөрсөн оны дансны авлагын дүнгээс хасч залруулсан тусгай зөвшөөрлийн жагсаалт”; “2018 оны оны дансны авлагын дүнгээс хасч залруулсан тусгай зөвшөөрлийн жагсаалт”-д заасан нэр бүхий ААН, иргэний урд оны болон тухайн тайлант жилийн авлагаар тооцсон дүнгээс залруулга хасалт хийж, тусгай зөвшөөрлийн программын төлвийг өөрчлөх, үүсгэсэн авлагыг залруулах арга хэмжээ авахыг холбогдох газар хэлтэст үүрэг болгов.

- Хорооны 2018 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар баталсан 2018 оны 44, 45, 46 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” нийт 3 тогтоолын хавсралтаар:
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 14 ААН, хуулийн этгээдэд 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 44 тоот тогтоолын хавсралтаар 15 тусгай зөвшөөрөл шинээр олгосон;
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, 10.3.1, 10.3.3 дах заалтыг тус тус үндэслэн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 45 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
  - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 12.1.1 дах заалт болон ДДэштв ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн 2018 оны 12 дугаар сарын



31-ний өдрийн 46 тоот тогтоолоор 12 хуулийн этгээдийн 12 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн.

Зохицуулах хорооны 2018 оны ээлжит 1 дүгээр хуралдааны 01 дүгээр тэмдэглэлээр тодорхой шалтгааны улмаас бүрэн хэрэгжээгүй, хугацаа болоогүй хуралдааны тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх талаар санал боловсруулж, 2018 оны 1 дүгээр улиралд багтаан хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д үүрэг болгосон юм. Уг ажлыг хэрэгжүүлэх зорилгоор хорооны 2018 оны ээлжит 4 дүгээр дугаар хуралдаанд, "Сонгон шалгаруулалтыг хүчингүй болсонд тооцох тухай" (Хорооны 2015 оны 33 тоот) танилцуулга, тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлэв. Энэхүү асуудлын талаар тус хуралдаанаас Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам"-ын 4.4.1 дэх заалтыг үндэслэн хорооны 2015 оны 33 дугаар тогтоолоор зарласан "Тоон телевизийн үндэсний сүлжээгээр дамжуулах өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн үйлчилгээ эрхлэгч"-ийн сонгон шалгаруулалтын хүчинтэй байх хугацаа дууссан тул "Сонгон шалгаруулалтыг хүчингүй болсонд тооцох тухай" 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 16 дугаар тогтоолыг батлан шийдвэрлэв. Хуралдааны 2017 оны 16 дугаар тэмдэглэлээр өгсөн "Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах зөвлөмж" боловсруулан шийдвэрлүүлэх асуудлыг Хорооны 2018 оны ээлжит 2 дугаар хуралдааны 4 тоот тогтоолын хавсралтаар баталж шийдвэрлэв.

Хорооны 2018 оны ээлжит 4 дүгээр хуралдаанд Төрийн аудитын тухай хуулийн 15.1, 18.2 заалт, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийсэн тайлан, дүгнэлтийг үндэслэн "ХХЗХ-ны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит"-ын талаар танилцуулгыг хэлэлцүүлэв. Зохицуулах хорооны 2017 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн хувьд холбогдох хууль тогтоомж, журам зааврын дагуу "зөрчилгүй санал, дүгнэлт" гэж Аудитын гэрчилгээнд илэрхийлсэн байдал, аудиторын өгсөн санал, зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллахыг Төсвийн захирагч-д хуралдаанаас зөвлөмж болгосон байна.

Үүрэн холбооны дугаартайгаа шилжих үйлчилгээний талаар 2014-2016 онд хууль тогтоомж, Хорооны хуралдаанаас баталсан тогтоол шийдвэр, хуралдааны Тэмдэглэлийн хэрэгжилтийн талаар танилцуулга, цаашид шат дараалан хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг ЗБХГ-тай хамтран боловсруулж, Хорооны даргын зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 10 дугаар хуралдаанд танилцуулж цаашид ажиллах удирдамж, чиглэлийг холбогдох газар, хэлтэст өглөө.

Хорооны 2018 оны ээлжит 5 дугаар хуралдаанаар "Зар сурталчилгааны талаар авах зарим арга хэмжээний тухай" асуудлыг боловсруулж хэлэлцүүлсэн ба 2018 оны 19 тоот "Зохицуулалт, нөхцөл шаардлагад нэмэлт оруулах тухай" тогтоолыг баталсан. Уг тогтоолоор Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 15 дугаар тогтоолын



хавсралтаар батлагдсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ын 7 дугаар зүйлийн 7.27-д “Нэг цагт дамжуулах зар сурталчилгааны хэтрэлтийн зөрчлийг тооцохдоо 18:00-23:59 цагийн хооронд дамжуулсан хөтөлбөрт эзлэх хэтрэлтийн нийт цагийг авч үзнэ” гэж нэмсэн бөгөөд нэмэлтийг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл дагаж мөрдөхөөр шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2018 оны ээлжит 5 дугаар хуралдааны 17 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Олон сувгийг олон цэгт түгээх системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу нийтээр даган мөрдөх хэм хэмжээнд хянуулан бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд 2018 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 01/861 тоотор хүргүүлсэн бөгөөд энэхүү баримт бичгийг ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн **3950** дугаарт 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр бүртгүүлэн баталгаажуулав. Уг тогтоолын хавсралтыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ([www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)), хорооны цахим хуудас ([www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn))-д тус тус байршуулан хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.

ХХЗХ-ны 2018 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар “Монгол Улсын Ерөнхий сайд буюу Төсвийн ерөнхийлөн захирагч болон ХХЗХ-ны дарга буюу Төсвийн шууд захирагчийн Бүтээгдэхүүн нийлүүлэх 2018 оны үр дүнгийн гэрээний биелэлт” болон “Байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан, төсвийн гүйцэтгэл”-ийн талаар тайланг тус тус хэлэлцүүлэв. Тус хорооны хуралдаанаас хэлэлцсэн асуудлаар холбогдох санал, дүгнэлтийг гаргалаа. Үүнд: “Монгол Улсын Ерөнхий сайд буюу Төсвийн ерөнхийлөн захирагч болон ХХЗХ-ны дарга буюу Төсвийн шууд захирагчийн Бүтээгдэхүүн нийлүүлэх 2018 оны үр дүнгийн гэрээ”-нд Төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлэхээр заасан арга хэмжээ, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүн болон 2 захиалгат бүтээгдэхүүнийг бүрэн хэрэгжүүлж гүйцэтгэсэн; “Байгууллагын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан”-д орсон зорилт, арга хэмжээнүүд, холбогдох төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, гүйцэтгэлийн хэрэгжилтийг ханган ажилласан; үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт, заалт бүрээр улирал тутам Дотоод хяналт, аудитын албаны үнэлгээ дүгнэлт гаргаж, хэрэгжилтэд тухайн бүр хяналт тавьж ажилласан нь үр дүнгээ өгсөн байна гэж дүгнэсэн болно. Мөн энэхүү хуралдаанаас Бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн 2018 оны гэрээний биелэлтийн тайлан, Хорооны 2018 оны үйл ажиллагааны тайланг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд загвар, маягтын дагуу боловсруулан нэгтгэж, Монгол Улсын Ерөнхий сайд (буюу Төсвийн ерөнхийлөн захирагч) болон Монгол Улсын Сайд, ЗГХЭГ-ын дарга нарт албан тоотор хүргүүлэх нь зүйтэй гэж тогтов.

Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хорооны 2018 оны ээлжит 6 дугаар хуралдаанаар хэлэлцэн 23 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”; хорооны 24 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Тоон радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага” баримт бичгийг нийтээр даган мөрдөх хэм



хэмжээнд хянуулан бүртгүүлэхээр ХЗДХЯ-нд Хорооны Даргын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 01/1012 албан тоотоор хүргүүлэн ХЗДХЯ-аар хянуулж Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн 3952 дугаар, 3953 дугаарт 2018 оны 7 дугаар сарын 06-ны өдөр тус тус бүртгүүлэн баталгаажуулсан. Эдгээр 2 тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ([www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)), хорооны цахим хуудас ([www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn))-д тус тус байршуулан хэрэгжилтийг зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 23 тоот тогтоолоор баталсан баримт бичгийг Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу тогтоолыг хавсралтын хамт нийтээр даган мөрдөх хэм хэмжээнд хянуулан бүртгүүлснээр тус хорооны 2018 оны 10 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх, гэрээнд тусгах арга хэмжээг авлаа.

ЗУХАГ-аас Захиргааны ерөнхий хуульд нийцээгүй, хуулиар журам гаргах эрх олгоогүй, үйлчлэх хугацаа дууссан, шинэчлэн батлах шаардлагатай журам, нөхцөл шаардлага, нэмэлт өөрчлөлтийг оруулж баталсан, дотооддоо Даргын тушаалаар батлан мөрдөх боломжтой зарим зохицуулалтын баримт бичгүүд, холбогдох хорооны тогтоолын судалгааг гаргаж, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн явцыг нэгтгэн хорооны 2018 оны ээлжит 8 дугаар хуралдаанд хэлэлцүүлэв. Энэхүү асуудлаар хорооны 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн “Тогтоол хүчингүй болгох тухай” 35 тоот тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн 49.1 дэх заалтыг үндэслэн баталсан. Тогтоолоор тус хорооны баталсан зарим журам, нөхцөл шаардлага, зохицуулалтын бичиг баримт, хуваарилалт болон холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан хорооны 8 тогтоолыг хавсралтын хамт хүчингүй болгон шийдвэрлэв.

Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, өөрчлөлт оруулах, шинэчлэн тогтоож 2018 оны хуралдаанаар баталсан зохицуулалтын баримт бичгийг ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлийн санд бүртгүүлэх, албан ёсны дүгнэлт зөвлөмж авах, түүний дагуу тогтоол шийдвэрийг нийцүүлэх, шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны Даргын 2017 оны А/259 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс тус хорооны эд хөрөнгийн үзлэг, тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журмын дагуу зохион байгуулав. Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам” болон 2017 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн “Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай” хорооны хуралдааны 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 25 тоот болон 26 тоот тогтоолыг тус тус батлав. Тогтоолын хавсралтаар баталсан нэр бүхий ашиглалтын хугацаа дууссан хэрэгцээ хангахгүй болсон машин, тоног төхөөрөмжийг; тавилга, эд хогшлыг; программ хангамжийг; ашиглалтын





хугацаа дуусч, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, сэргээн засварлахад өртөг өндөртэй, цаашид байгууллагын хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй болсон авто тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгөнөөс хасч актлах, устгах саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэхээр тогтов.

Хорооны 2018 оны 29 тоот тогтоол, хавсралтаар баталсан “Дотоодод борлуулах интернетийн урсгалын бөөний үйлчилгээний доод үнэ”-ийг ЖЕМНЭТ ХХК, МХС ХХК, Мобиком корпораци ХХК, Юнител ХХК, МЦХ ХК-д албан тоотоор хүргүүлж, байгууллагын цахим хуудаст албажуулан байршуулан мөрдүүлэн хяналт тавьж ажилласан.

ХХЗХ-ны 2018 оны хуралдааны тогтоол шийдвэр, тэмдэглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, батлагдсан зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлагын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд холбогдох яам, байгууллага, дүүрэг, татварын алба, мэргэжлийн хяналтын газар, ААН, тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээд нарт 1300 гаруй албан тоотоор тус тус албажуулан хүргүүлэх арга хэмжээг авч ажиллав. Тухайлбал, хорооны 2018 оны ээлжит 1-11 дүгээр хуралдааны нийт 30 тогтоолоор шийдвэрлэсэн тусгай зөвшөөрлийн албан мэдэгдлийг хүргүүлсэн ба тусгай зөвшөөрлийн албан мэдэгдлийг хуулийн этгээдэд, хуулбарыг холбогдох татвар, мэргэжлийн хяналтын газар, хэлтэст албан тоотоор албажуулан хүргүүлэх арга хэмжээг авлаа. Тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон талаар ЗУХАГ-аас мэдээллийн санд тухай бүр тодотгол хийж ажилласан болно. ЗУХАГ-аас тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй гэрээ байгуулан тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн гэрээг байгуулав.

Тус хорооноос Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль, тогтоомжид хорооны тогтоол, шийдвэрийг нийцүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү арга хэмжээний хүрээнд 2002 оноос хорооны хуралдаанаар баталсан 180 гаруй тогтоол, нэмэлт өөрчлөлтийг хянан үзэж, ЗЕХ-д нийцүүлэн батлах, хүчингүй болгох, баталсан тогтоол шийдвэрийг ХЗДХЯ-д хүргүүлэн хянуулж, Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд бүртгүүлж байна. Бүртгүүлсэн хорооны тогтоолыг хавсралтын хамт Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем ([www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)), хорооны цахим хуудас ([www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn))-д тус тус байршуулсан.

Байгууллагын цахим хуудаст Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хорооны хуралдаанаар 2018 онд хүчингүй болгосон нийтдээ 18 тогтоол, хавсралтын талаар мэдээллийг тус тус шинэчлэн оруулав.

ХХЗХ-ны 2018 оны ээлжит 11 удаагийн хуралдаанаар асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн нийт 46 тогтоол, шийдвэрийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, хорооны хуралдаанаар батлагдсан тогтоол, тогтоолын хавсралтуудыг тусгай фолдерт байршуулан албан дотоод хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлэх ажилласан. Түүнчлэн салбарын зохицуулалтын баримт бичиг, дүрэм журам, тусгай зөвшөөрлийн шинээр батлагдсан, шинэчилсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан журам, нөхцөл шаардлага болон 2018 оны хорооны хуралдааны шийдвэр, тогтоолын хавсралтыг татах файлын хамт HTML хэлбэрээр оруулж, олон нийтэд



нээлттэй сурталчилах, зөвлөмж гарын авлага хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлэн ажилласан болно.

Хорооны 2018 оны 11 удаагийн ээлжит хуралдааны мэдээлэл болон тогтоол, тэмдэглэл, батлагдсан баримт бичгийг хавсралтын хамт, тайлан мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтэд сурталчилах, хорооны шийдвэрийг нээлттэй болгон ажиллав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны тогтоол шийдвэр, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг зохион байгуулж, хуралдаанд танилцуулах, хэлэлцүүлэх, хуралдааны тэмдэглэлээр өгсөн удирдамж, үүрэг даалгаврыг холбогдох бүтцийн нэгжийн дарга нарт мэдэгдэх, биелэлтийн тайланг нэгтгэн гаргаж, тухай бүр удирдлагад танилцуулан Дотоод хяналт, аудитын алба хяналт шинжилгээ аудит хийж зөвлөмж гарган биелэлтэнд хяналт тавьж ажилласан.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь 2018 онд төлөвлөсөн ажил зорилтоо амжилттай хэрэгжүүлж, хууль эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлэх, зохицуулалтын баримт бичгийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, шинэчлэн батлах, өрсөлдөөн зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, хэлэлцүүлэг, бүсийн уулзалт семинар зохион байгуулах, хяналт шалгалт хийх, судалгаа боловсруулах зэрэг чиглэлээр олон ажлыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын харилцаа холбоо, шуудан, мэдээллийн технологийн хөгжлийн бодлого, нэгдсэн бодлого, төлөвлөлтийг бэхжүүлэх, төрийн захиргааны байгууллагын бодлогын хүрээнд зохицуулалт, өрсөлдөөний орчинг боловсронгуй болгосноор мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын зохицуулалтын арга хэрэгслээр зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, мэдээллийн дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, цахим засаглалыг бий болгох, шинэлэг бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан эрэлт, хэрэгцээг хангасан шинэ төрлийн хэрэглээ, үйлчилгээг нэвтрүүлэх, дэмжих эрх зүйн шинэ зохицуулалтыг шаардаж байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хөгжлийн чиг хандлага, техник технологийн ололт үйлдвэрлэл, өргөн зурвасын сүлжээ, хэрэглээний өсөлт, оролцогч бүх талын оролцоо хамтын ажиллагааг дэмжих, учирч буй шинэ хүндрэл бэрхшээл зэргийг харгалзан салбарын хууль эрх зүйн шинэчлэлтийг цаг алдалгүй хийх, төрийн үйлчилгээ ба хэрэглээг цахимжуулах, нэгдсэн бодлого төлөвлөлт, зохицуулалтын үйл ажиллагааг сайжруулах нь бидний чухал зорилт гэж үзэж байна.

**ХАВСРАЛТ-1: ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХУРАЛДААНААС 2018 ОНД БАТАЛСАН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН НЭГДСЭН СУДАЛГАА, 3 ХУУДАС;**

**ХАВСРАЛТ-2: ХХЗХ-НЫ ХУРАЛДААНААР 2018 ОНД ШИЙДВЭРЛЭСЭН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН СУДАЛГАА, 2 ХУУДАС;**



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**  
2018-12-31



ХАВСРАЛТ-1:

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ХУРАЛДААНААС 2018 ОНД БАТАЛСАН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН  
НЭГДСЭН СУДАЛГАА

2018.12.31

№	Хорооны баталсан тогтоол, тэмдэглэлийн дугаар	Огноо	Тогтоол, тэмдэглэлийн товч агуулга
<b>Нэг. ХХЗХ-ны баталсан тогтоол</b>			
1	Тогтоол 01	2018.01.31	Тусгай зөвшөөрөл олгох тухай
2	Тогтоол 02	2018.01.31	Тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулах тухай
3	Тогтоол 03	2018.01.31	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
4	Тогтоол 04	2018.02.22	Зөвлөмж батлах тухай (Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хүүхэд хамгаалах чиглэлээр баримтлах зөвлөмж)
5	Тогтоол 05	2018.02.22	Тусгай зөвшөөрөл олгох тухай
6	Тогтоол 06	2018.02.22	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай
7	Тогтоол 07	2018.02.22	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
8	Тогтоол 08	2018.03.29	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай (2016 оны 43 дугаар тогтоол: “Хорооны хуралдааны дэг”)
9	Тогтоол 09	2018.03.29	Тусгай зөвшөөрөл олгох тухай
10	Тогтоол 10	2018.03.29	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай
11	Тогтоол 11	2018.03.29	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
12	Тогтоол 12	2018.04.27	Тусгай зөвшөөрөл олгох тухай
13	Тогтоол 13	2018.04.27	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай
14	Тогтоол 14	2018.04.27	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай
15	Тогтоол 15	2018.04.27	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
16	Тогтоол 16	2018.04.27	Сонгон шалгаруулалтыг хүчингүй болсонд тооцох тухай (2015 оны 33 дугаар тогтоол)
17	Тогтоол 17	2018.05.30	Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай (Олон сувгийг олон цэгт түгээх системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага)
18	Тогтоол 18	2018.05.30	Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагад нэмэлт оруулах тухай (2017 оны 31 тоот тогтоолын хавсралт)
19	Тогтоол 19	2018.05.30	Зохицуулалт, нөхцөл шаардлагад нэмэлт оруулах тухай (2015 оны 15 тоот тогтоолын хавсралт)



20	Тогтоол 20	2018.05.30	Тусгай зөвшөөрөл олгох тухай
21	Тогтоол 21	2018.05.30	Тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулах тухай
22	Тогтоол 22	2018.05.30	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
23	Тогтоол 23	2018.06.22	Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай
24	Тогтоол 24	2018.06.22	Тоон радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай (DAB+)
25	Тогтоол 25	2018.06.22	Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай
26	Тогтоол 26	2018.06.22	Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасч, актлах тухай
27	Тогтоол 27	2018.06.22	Тусгай зөвшөөрөл олгох тухай
28	Тогтоол 28	2018.06.22	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
29	Тогтоол 29	2018.07.19	Үнэ тариф тогтоох тухай
30	Тогтоол 30	2018.07.19	Тусгай зөвшөөрөл олгох тухай
31	Тогтоол 31	2018.07.19	Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай
32	Тогтоол 32	2018.07.19	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
33	Тогтоол 33	2018.08.31	Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагад нэмэлт оруулах тухай (Хорооны 2017 оны 42 тоот тогтоол)
34	Тогтоол 34	2018.08.31	Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагад нэмэлт оруулах тухай (Хорооны 2017 оны 44 тоот тогтоол)
35	Тогтоол 35	2018.08.31	Тогтоол хүчингүй болгох тухай (ЗЕХ-д нийцүүлэх, хэрэгжүүлэх-8 тогтоол)
36	Тогтоол 36	2018.08.31	Тусгай зөвшөөрөл олгох тухай
37	Тогтоол 37	2018.08.31	Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
38	Тогтоол 38	2018.08.31	Тусгай зөвшөөрөл сэргээх тухай
39	Тогтоол 39	2018.08.31	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
40	Тогтоол 40	2018.10.02	Тусгай зөвшөөрөл олгох тухай
41	Тогтоол 41	2018.10.02	Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
42	Тогтоол 42	2018.10.02	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай
43	Тогтоол 43	2018.11.13	"Хорооны хуралдааны урамшууллын хэмжээ"-г тогтоох тухай
44	Тогтоол 43	2018.12.31	Тусгай зөвшөөрөл олгох тухай
45	Тогтоол 43	2018.12.31	Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
46	Тогтоол 43	2018.12.31	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

**Хоёр. Хорооны хуралдааны тэмдэглэл**

1	Тэмдэглэл-01	2018.01.31	Хорооны хуралдааны 2017 оны жилийн эцсийн тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай
2	Тэмдэглэл-02	2018.01.31	Өргөн нэвтрүүлгийн нөхцөл, шаардлагын талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай



3	Тэмдэглэл-03	2018.03.29	Үнэ тарифын талаар авах арга хэмжээний тухай
4	Тэмдэглэл-04	2018.03.29	Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн 2017 оны тайлан, үр дүнгийн талаар авах зарим арга хэмжээний тухай
5	Тэмдэглэл-05	2018.03.29	МҮОНРТ-ийн нэмэлт сувгийн тухай
6	Тэмдэглэл-06	2018.04.27	Зар сурталчилгааны талаар авах зарим арга хэмжээний тухай
7	Тэмдэглэл-07	2018.04.27	Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийн тухай
8	Тэмдэглэл-08	2018.05.30	“ХХЗХ-ны найдваргүй авлагын нөөцийн сан байгуулах журам”-ын төслийн тухай
9	Тэмдэглэл-09	2018.05.30	Тусгай зөвшөөрлийн үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай
10	Тэмдэглэл-10	2018.06.22	Хорооны 2018 оны 23 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
11	Тэмдэглэл-11	2018.06.22	ХХЗХ-ны найдваргүй авлагын нөөцийг бүрдүүлэх талаар авах арга хэмжээний тухай
12	Тэмдэглэл-12	2018.12.31	Шуудангийн үнэ тарифын тухай
13	Тэмдэглэл-13	2018.12.31	Тусгай зөвшөөрлийн тухай
14	Тэмдэглэл-14	2018.12.31	Тусгай зөвшөөрлийн гэрээний нөхцөл шаардлага, хэрэгжилтийг хангуулах тухай
15	Тэмдэглэл-15	2018.12.31	Дансны авлагын талаар авах арга хэмжээний тухай
16	Тэмдэглэл-16	2018.12.31	Урамшуулал олгох тухай

-----oOo-----



ХАВСРАЛТ-2:

ХХЗХ-НЫ ХУРАЛДААНААР 2018 ОНД ШИЙДВЭРЛЭСЭН  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
СУДАЛГАА

Д/д	Тогтоол ын дугаар	Тогтоолын огноо	Тусгай зөвшөөрлийн тоо				
			Шинээр олгосон	Сэргээ- сэн	Өөрчлөлт оруулсан	Түдгэл- зүүлсэн	Хүчингүй болгосон
1	1	2018.01.31	5				
2	2	2018.01.31			1		
3	3	2018.01.31					1
4	5	2018.02.22	14				
5	6	2018.02.22			2		
6	7	2018.02.22					1
7	9	2018.03.29	23				
8	10	2018.03.29			6		
9	11	2018.03.29					3
10	12	2018.04.27	22				
11	13	2018.04.27			2		
12	14	2018.04.27				1	
13	15	2018.04.27					4
14	20	2018.05.30	16				
15	21	2018.05.30			1		
16	22	2018.05.30					3
17	27	2018.06.22	8				
18	28	2018.06.22					1
19	30	2018.07.19	9				
20	31	2018.07.19			4		
20	32	2018.07.19					7
21	36	2018.08.31	10				
22	37	2018.08.31			2		
23	38	2018.08.31		1			
24	39	2018.08.31					1
25	40	2018.10.02	3				
26	41	2018.10.02			2		
27	42	2018.10.02					1
28	44	2018.12.31	15				



29	45	2018.12.31			6		
30	46	2018.12.31					12
		<b>Нийт</b>	<b>125</b>	<b>1</b>	<b>26</b>	<b>1</b>	<b>34</b>

-----oOo-----